



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 28 өдөр

Дугаар A/79

Мандалговь

Г МУУГЗ Д.Доржсүрэн, Олон улсын тэмцээнд
амжилт гаргасан Дэрэн сумын харьят
Х.Түмэн-Өлзий нарыг шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дүгээр захирамжаар батлагдсан "Урамшууллын жишиг тогтоох журам"-ын 2.1, 3.2.1 дэх заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 4 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, Төрийн соёрхолт Зууны манлай уртын дуучин Н.Норовбандадын нэрэмжит Төв Халхын дуулалт жүжгийн театрын дарга Дэлгэрэйн Доржсүрэн Төрийн дээд шагнал "Монгол Улсын Үрлагийн Гавьяат зүтгэлтэн" цол хүртсэн тул аймгийн Засаг даргын "Хүндэт өргөмжлөл", мөнгөн шагналаар шагнасугай.


Хоёр. Дэрэн сумын уугул Х.Түмэн-Өлзий Малайз улсын Куала Лумпур хотноо зохиогдсон Олон улсын 23 дахь удаагийн "Цээж тоолол, соробан сампингийн аварга шалгаруулах тэмцээний А түвшинд оролцож, "Алтан цом" хүртсэн тул шагнаж урамшуулсугай.

Гурав. Шагнал урамшууллын зардлыг хавсралтаар баталсугай.

Дөрөв. Мөнгөн шагналд 800000 (Найман зуун мянга), Хүндэт өргөмжлөл хэвлүүлэхэд 35000 (Гучин таван мянга), нийт 835000 (Найман зуун гучин таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488190220



Аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын
28.-ны өдрийн 79 тоот захирамжийн хавсралт

ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Овог, нэр	Ажил, албан тушаал, сургууль	Хүртсэн шагнал, гаргасан амжилт	Шагналын болон зардлын мөнгөн дүн
1	Дэлгэрийн Доржсүрэн	Төв Халхын дуулалт жүжгийн театрын дарга	Монгол Улсын Үрлагийн Гавьяат зүтгэлтэн	500000
2	Хүндэт өргөмжлөл хийлгэх			35000
3	Хашбаатар Түмэн-Өлзий	Сонгино хайрхан дүүргийн Ирээдүй цогцолбор сургуулийн бага сургуулийн 2 дугаар ангийн сурагч	Цээж тоолол, соробан сампингийн аварга шалгаруулах тэмцээний Алтан цом	300000
	ДҮН			835000